



Агуулга

Товчилсон үг	2
Хүснэгтийн товъёг	2
Дүрслэлийн товъёг	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	3
Үндсэн мэдээлэл	4
1.1 Улсын төсвөөс олгох хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг бодитой тооцсон уу?	4
1.2 Сонгуулийн хороодод зардлын төсвийг үндэслэлтэй хуваарилсан уу?	5
Хоёр. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх.....	6
2.1 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу, арвилан хэмнэлттэй зарцуулсан уу?.....	6
2.4 Хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналт үр дүнтэй байна уу?	8
Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	9
Байгууллагаас ирүүлсэн хариу.....	10
Тэмдэглэл	11



Товчилсон үг

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
УИХ	Улсын их хурал
УБХ	Улсын бүртгэлийн хэлтэс
ЦГ	Цагдаагийн газар
ШӨХТГ	Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар
ҮСХ	Үндэсний Статистикийн хороо
ИТХ	Иргэдийн төлөөлөгчийн хурал
АСХ	Аймгийн Сонгуулийн хороо
ССХ	Сумын Сонгуулийн хороо

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Санхүүжилт	4

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Харьцуулалт	5
Дүрслэл 2	Эзлэх хувь	7
Дүрслэл 3	Схем	8



Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.6-д заасан бүрэн эрхийн хүрээнд “Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан улсын төсвөөс санхүүжүүлсэн Говь-Алтай аймгийн Сонгуулийн хорооны Сонгуулийн зардлын төлөвлөлт, зарцуулалт”-д аудит хийлээ.
Аудитын зорилт	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдуулан Говь-Алтай аймагт улсын төсвөөс хуваарилан санхүүжилт олгосон зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан УИХ, Засгийн газар, холбогдох байгууллагад танилцуулж, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд: Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэнэ. Үүнд: ➤ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх ➤ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх
Аудитын хамарсан хүрээ	Сонгууль зохион байгуулахтай холбоотой Говь-Алтай аймагт хуваарилагдан ирсэн санхүүжилтийг /Аймгийн Сонгуулийн хороо, сумуудын Сонгуулийн хороо, Улсын бүртгэлийн хэлтэс, Цагдаагийн газар, Онцгой байдлын газар/ хамруулан шалгалаа.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 3000, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-1, 6817-5, 6817-7, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмыг ашиглан Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, тулган баталгаажуулах, давтан тооцоолох горим сорил ашиглан үндсэн үзүүлэлтийн судалгаанд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр удирдаж, аудитын менежер Д.Эрдэнэчимэг чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Цэцэгмаа, аудитор Х.Билэгбаяр, С.Санчирмаа нар гүйцэтгэв. Аудитын гүйцэтгэх үе шатны талбарын ажлыг 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс 2021 оны 07 дугаар сарын 05-ны өдөр хүртэл цахимаар гүйцэтгэж, аймгийн нэгтгэлийг 2020 оны 07 дугаар сарын 05-нд хийж аудитын тайланг баталгаажуулан Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв.
Хүндрэл бэрхшээл	Аудит хийхэд аймгийн Сонгуулийн хорооны гүйлгээ 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдөр болтол дуусаагүй нэгтгэсэн тайлан гараагүй байдал хүндрэлтэй байлаа.



Үндсэн мэдээлэл

Говь-Алтай аймаг 5 дугаар тойрогт хамрагдаж сонгууль зохион байгуулах ажилд 1 тойрогт аймгийн 1 хороонд 9 ажилтан, сумын 18 хороонд 126 ажилтан, Сонгуулийн 88 хэсгийн хороонд 688 ажилтан, мэдээлэл технологийн багт 5 хүн, сумдын даамлаар 95 ажилтан, нөөц даамлаар 12 ажилтан, улсын бүртгэлийн 91 итгэмжлэгдсэн ажилтан, 127 цагдаагийн албан хаагч, 1 тагнуулын ажилтан, санал авах ажиллагаанд 2 эрүүл мэндийн ажилтан нийт 1156 ажилтан албан хаагч ажилласан байна.

Хүснэгт №1

Санхүүжилт

мян.төг

№	Байгууллагын нэр	Санхүүжилт	Гүйцэтгэл	Хэмнэлт
1	Аймгийн Сонгуулийн хороо	630,293.0	588,729.9	41,563.1
2	Улсын бүртгэлийн хэлтэс	82,097.0	82,097.0	-
3	Цагдаагийн газар	12,600.0	12,600.0	-

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулахтай холбоотойгоор Говь-Алтай аймагт хүснэгт №1-д дурдсан санхүүжилт ирж зарцуулагдсан байна.

БҮЛЭГ 1

ДҮГНЭЛТ: АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРООНД СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ ИРСЭН САНХҮҮЖИЛТИЙГ ГҮЙЦЭТГЭЛЭЭР ХУВААРИЛСАН БАЙНА.

Нэг. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журам, зориулалтын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх

1.1 Улсын төсвөөс олгох хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг бодитой тооцсон уу?

Говь-Алтай аймаг буюу Монгол Улсын Ерөнхийлөгчийн Сонгуулийн 5 дугаар тойрогт ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотойгоор 3 байгууллагад 724,990.0 мянган төгрөгийн санхүүжилт хуваарилагдан ирж гүйцэтгэлээр 683,426.9 мянган төгрөгийг зарцуулж 41,563.1 мянган төгрөгийг улсын төсөвт буюу Сонгуулийн Ерөнхий Хороонд төвлөрүүлсэн байна. /Хүснэгт №1/

Сонгууль зохион байгуулахтай холбоотойгоор хуваарилагдан ирсэн санхүүжилтийг олгохын өмнө төсөв хуваарилагдан ирсэн нэгж байгууллагуудаас төсвийн төсөлд санал, тайлбар тооцоо судалгаа аваагүй байна.

Анх батлагдсан төсвийн дүнд өөрчлөлт орсон байгууллага байхгүй байна.

Аймгийн Сонгуулийн хороонд хуваарилагдан ирсэн санхүүжилтийг анхан шатны баримтад тулгуурлан гаргаснаар 41,563.1 мянган төгрөгийн бодит хэмнэлт үүссэн ба хэмнэлт гарсан зардлуудад дүн шинжилгээ хийхэд дутуу хэрэгжсэн, хэрэгжээгүй ажил байхгүй байна.

Дээрх 3 байгууллагад хуваарилагдан ирсэн санхүүжилт нь тус байгууллагуудын төрийн санд байршдаг бүртгэлийн данс, нэмэлт дансаар орж ирж нэг хоёрдугаар гарын үсэг зурсан албан тушаалтан болон төрийн сангийн хяналттайгаар зарцуулагдсан байна.

Сонгууль зохион байгуулах ажилд 1 тойрогт аймгийн 1 хороонд 9 ажилтан, сумын 18 хороонд 126 ажилтан, Сонгуулийн 88 хэсгийн хороонд 688 ажилтан, мэдээлэл технологийн багт 5 хүн, сумдын даамлаар 95 ажилтан, нөөц даамлаар 12 ажилтан, улсын бүртгэлийн 91 итгэмжлэгдсэн ажилтан, 127 цагдаагийн албан хаагч, 1 тагнуулын ажилтан, санал авах



ажиллагаанд 2 эрүүл мэндийн ажилтан нийт 1156 ажилтан албан хаагчийн бүрэлдэхүүн Сонгуулийн хороо хэсэг санал авах байранд ажилласан ба Сонгуулийн үйл ажиллагаанд холбогдох шийдвэрийн дагуу томилогдсон хүний нөөцийг бүрэн ашиглажээ.

Мөн коронавируст халдвараас шалтгаалан онцгой байдал эрүүл мэндийн байгууллагын холбогдох ажилтнууд халдвар хамгааллын дэглэм сахиулах, оношилгоо шинжилгээнд хамруулах байдлаар оролцсон байна.

1.2 Сонгуулийн хороодод зардлын төсвийг үндэслэлтэй хуваарилсан уу?


Аймгийн Сонгуулийн хороонд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс 630,293.0 мянган төгрөгийг хуваарилсан байна.

Сонгуулийн Ерөнхий хорооноос санхүүжилт хуваарилах бүртээ холбогдох задаргаа тайлбар зөвлөмж өгч ажилласан байна.

Аймгийн Сонгуулийн хороо нь Сонгуулийн Ерөнхий хорооноос өгсөн зөвлөмж аргачлалын дагуу сумын Сонгуулийн хороо, хэсгийн хорооны төсвийг хэсгийн хорооны тоо, хүн амын тоо, газар нутгийн хэмжээнээс хамаарч батлагдсан төсвийг гүйцэтгэлээр хуваарилжээ.

Дүрслэл №1

Харьцуулалт



Сонгуулийн Ерөнхий хорооноос ирүүлсэн зөвлөмж аргачлалын дагуу хуваарилалт хийхэд сумын Сонгуулийн хороо, хэсгийн хороодод хуваарилбал зохих 64,383.8 мянган төгрөгийн төсвийг сумын Сонгуулийн хороодод хуваарилаагүй байна. Зардлыг бодит гүйцэтгэлээр санхүүжүүлсэн болон бичиг хэрэг, санал авах байр бэлтгэх тохижуулах зардлын тодорхой хувь, унааны зардлын тодорхой хувийг нэгдсэн зохион байгуулалтаар санхүүжүүлснээр хэмнэлт үүсэх шалтгаан болсон байна. Дүрслэл №1-т хуваарилсан санхүүжилт, түүний гүйцэтгэлийг харууллаа.



БҮЛЭГ 2

СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ ГАРСАН ЗАРДЛЫГ ГҮЙЦЭТГЭЛЭЭР БУЮУ АРВИЛАН ХЭМНЭЛТТЭЙ ЗАРЦУУЛСАН БАЙНА.

Хоёр. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх

2.1 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу, арвилан хэмнэлттэй зарцуулсан уу?

Сонгууль зохион байгуулахтай холбогдуулан хуваарилагдсан төсвийг зориулалтын дагуу, арвилан хэмнэлттэй холбогдох хууль тогтоомж түүнийг даган гарсан шийдвэрт үндэслэсэн эсэхийг анхан шатны баримтаас 100 хувь давтан тооцсон. Аймаг, сумдын Сонгуулийн хороо хэсгүүдийн баримт материал эмх цэгцтэй, зардал гаргахдаа Сонгуулийн Ерөнхий Хороо, аймгийн Сонгуулийн хорооноос өгсөн чиглэлийг баримталсан байна.

Зардлын гүйцэтгэлийг анхан шатны баримтаас давтан тулган баталгаажуулахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Сонгууль зохион байгуулахтай холбогдуулан хуваарилагдсан зарцуулагдсан зардлаас аймгийн Сонгуулийн хорооноос гарсан 2,250.0 мянган төгрөг, сумуудын Сонгуулийн хорооноос гарсан 1,674.6 мянган төгрөг нийт 3,924.6 мянган төгрөгийн хөрөнгө бий болсныг данс бүртгэлд тусгаагүй байна.
- Сонгууль зохион байгуулахтай холбогдуулан хуваарилагдсан аймгийн Сонгуулийн хорооны унааны зардлын гүйцэтгэлийг гаргахад 752.7 мянган төгрөгийн ХХОАТ суутган тооцсон боловч татварын байгууллагад шилжүүлээгүй, сумдын Сонгуулийн хорооны унааны зардлын гүйцэтгэлийг анхан шатны баримтад тулгуурлан хэсгийн хорооны ажилчдаас утсаар тодруулга авах байдлаар тулган баталгаажуулахад 1,584.2 мянган төгрөгийн шатахууныг зарцуулснаар тайлагнасан.
- Сонгууль зохион байгуулахтай холбогдуулан хуваарилагдсан албан томилолтын зардлын гүйцэтгэлийг тулган баталгаажуулахад 150.0 мянган төгрөгийг албан томилолтын хуудасгүй байхад олгосон.
- Сонгууль зохион байгуулахтай холбогдуулан хуваарилагдсан санал авах байр бэлтгэх тохижуулах зардлаас аймгийн Сонгуулийн хороо нь төрийн далбаа худалдан авсан бэлтгэн нийлүүлэгчид олгосон 3,600.0 мянган төгрөг (И баримт) татварын нэгдсэн системд худалдан авалт хийсэн төлбөрийн баримт хэсэгт бүртгэгдээгүй
- Сонгууль зохион байгуулахтай холбогдуулан хуваарилагдсан болзошгүй зардлаас 9,801.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан
- Бараа материалд үлдэгдэлтэй 2,250.0 мянган төгрөгийн шатахууны талоныг бэлэн мөнгөнд шилжүүлж дансанд тушаагаагүй байлаа.

Аудитын хугацаанд залруулсан цаашид анхаарвал зохих дараах асуудлууд байна. Үүнд:


- Сонгууль зохион байгуулахтай холбогдуулан хуваарилагдсан зарцуулагдсан зардлаас бий болсон 3,924.6 мянган төгрөгийн аж ахуйн материалыг харьяа аймаг сумдын Засаг даргын тамгын газарт данс бүртгэлд тусгуулсан.
- Бараа материалд үлдэгдэлтэй 2,250.0 мянган төгрөгийн шатахууны талоныг бэлэн мөнгөнд шилжүүлж дансанд тушаалгасан.



- Сонгууль зохион байгуулахтай холбоотой гарсан зардлаас хөрөнгө бий болсон бол нягтлан бодох бүртгэлд орлого авч байх
- Сонгууль зохион байгуулахтай холбоотой гарч байгаа бараа материал бэлтгэн хуваарилж байгаа зардлыг бараа материалд бүртгэн зарцуулах
- Иргэн, аж ахуйн нэгжээс НӨАТ-ын баримтыг тухай бүр авч байх
- Сонгууль зохион байгуулахтай холбоотой гарсан зардлын зарцуулалтын анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаж авах

2.2 Зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан уу?

Дүрслэл № 2 Эзлэх хувь



Сонгууль зохион байгуулахтай холбогдуулан аймгийн Сонгуулийн хороо, Улсын бүртгэлийн хэлтэс, Цагдаагийн газарт нийт 724,990.0 мянган төгрөг хуваарилагдан ирсэн ба аудитаар цагдаагийн газарт хуваарилагдсан ирсэн 12,600.0 мянган төгрөгөөс бусад зардлын гүйцэтгэлийг холбогдох байгууллагаас ирүүлсэн баримт материалд үндэслэн тулган баталгаажуулсан. Аймгийн Сонгуулийн хороо нь Сонгуулийн Ерөнхий хорооны даргын 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/17 дугаартай захирамж болон Сонгуулийн Ерөнхий хорооны даргын 2021 оны 03 дугаар сарын 1/123 дугаартай чиглэл, 2021 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 1/251 дугаартай албан даалгавар Сонгуулийн Ерөнхий хорооны ажлын албаны 2021 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 3/71, 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 3/103, 2021 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 3/124 дугаартай албан бичгүүдээр ирүүлсэн санхүүжилтийн хуваарь тайлбарын дагуу аймаг, сумдын Сонгуулийн хороодод зардал хуваарилан зарцуулж Сонгуулийн хороо бүрээс зарцуулалтын тайлан авч аймгийн Сонгуулийн хорооны нягтлан бодогч нэгтгэсэн байна. Гарсан зардлын гүйцэтгэлийг тулгахад дансны хуулгатай зөрүүгүй тохирч байна.

Аймгийн Сонгуулийн хороо нь улсын төсвөөс хуваарилагдан ирсэн санхүүжилтийн 83 хувь буюу 520,743.2 мянган төгрөгийг сумдад хуваарилснаас 15,990.0 мянган төгрөгийг бэлэн бус хэлбэрээр буюу шатахууны талоноор олгожээ. Аймгийн Сонгуулийн хороо 40,226.5 мянган төгрөг, сумуудын Сонгуулийн хороо 1,611.6 мянган төгрөг нийт 41,563.1 мянган төгрөгийн хэмнэлтийг Сонгуулийн Ерөнхий хорооны төрийн санд байршиж буй бүртгэлийн дансанд төвлөрүүлсэн байна.

Улсын бүртгэлийн хэлтэст сонгууль зохион байгуулахтай холбоотойгоор урамшуулал, албан томилолт, сургалт, унаа, бичиг хэргийн зардалд зарцуулах 82,097.0 мянган төгрөгийн санхүүжилт тус байгууллагын төрийн санд байршдаг нэмэлт дансанд хуваарилагдаж бараа үйлчилгээний бусад зардал ангилалд тайлагнагдсан байна.

Цагдаагийн газарт сонгууль зохион байгуулахтай холбоотойгоор Цагдаагийн ерөнхий газраас бэлнээр 12,600.0 мянган төгрөг ирж зарцуулагдсан ба ээлжит Сонгуулийн хамгаалалтын зардлын тайланг Цагдаагийн Ерөнхий газарт нэгтгүүлж баримт материалаа татуулсан талаар 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 31/2716 дугаартай албан бичгээр мэдэгдсэн.



2.4 Хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналт үр дүнтэй байна уу?

Дүрслэл №3 Схем

Сонгууль зохион байгуулахтай холбогдон ирсэн санхүүжилт нь байгууллагуудын төрийн санд байршдаг бүртгэлийн данс, нэмэлт дансаар орж ирж нэг, хоёрдугаар гарын үсэг зурсан албан тушаалтнуудын хяналт болон давхар төрийн сангийн хяналтад зарцуулагдсан байна. Аймгийн Сонгуулийн хорооны зардлын зарцуулалтыг аймгийн Сонгуулийн хорооны дарга, нягтлан бодогч, сумдын Сонгуулийн хорооны зарцуулалтыг сумдын Сонгуулийн хорооны дарга, нягтлан бодогч нар харьяа төрийн сандаа гарын үсгийн баталгаа гарган хийсэн байна. Аудитын явцад сонгууль зохион байгуулахтай холбогдуулан гарсан зардлын зарцуулалтын анхан шатны баримт материалтай танилцахад эмх цэгцтэй, зарцуулалт хийхдээ аймгийн Сонгуулийн хороо нь болзошгүй зардлаас бусад зардлын тухайд Сонгуулийн Ерөнхий хорооноос ирүүлсэн тайлбар болон холбогдох хууль тогтоомжийг, бусад байгууллагын тухайд зарцуулалт хийхдээ холбогдох хууль тогтоомжийг баримталсан байна.



Хөрөнгийн зарцуулалтад үр дүнтэй хяналт тавьж ажиллажээ.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТААР ӨГСӨН ШИЙДВЭР:

АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРООНЫ ДАРГА Ц.БАТЗОРИГТ

ТӨЛБӨРИЙН АКТ

1. Төсвөөс үндэслэлгүй илүү зарцуулсан 1,734.2 мянган төгрөгийг аймгийн орон нутгийн төсвийн орлогын 100050000982 тоот дансанд төвлөрүүлэх, 752.7 мянган төгрөгийн ХХОАТ-ыг аймгийн татварын орлогын 100050000901 тоот дансанд төвлөрүүлэх

АЙМГИЙН САНХҮҮ ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Х.БААТАРЗОРИГТ

АЛБАН ШААРДЛАГА

1. Нэгж байгууллагын бүртгэлийн данснаас зарцуулалтын гүйлгээ хийхдээ татварын нэгдсэн системд худалдан авалт хийсэн төлбөрийн баримт (И баримт) хэсэгт бүртгэгдсэн баримт болон холбогдох хууль тогтоомж дээд газраас ирүүлсэн шийдвэрт нийцсэн эсэхийг нягталж үр дүнтэй хяналт тавих

ДҮГНЭЛТ: СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ ХУВААРИЛАГДАН ИРСЭН САНХҮҮЖИЛТИЙГ ҮР ДҮНТЭЙ ЗАРЦУУЛСАН БАЙНА.



Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:

2021

Аудитын
нэр:

“Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан улсын төсвөөс санхүүжүүлсэн Говь-Алтай аймгийн Сонгуулийн хорооны Сонгуулийн зардлын төлөвлөлт, зарцуулалт”

Аудитын код:

ГАА-2021/31-ШГА-ГА

Шалгагдсан
байгууллагын нэр:

Говь-Алтай аймгийн Сонгуулийн хороо

Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	6
1	Сонгууль зохион байгуулахтай холбогдуулан хуваарилагдсан аймгийн Сонгуулийн хорооны унааны зардлын гүйцэтгэлийг гаргахад 752.7 мянган төгрөгийн ХХОАТ суутган тооцсон боловч татварын байгууллагад шилжүүлээгүй	752.7	Төлбөрийн акт тогтоох	Дарга, Нягтлан бодогч	Ц.Батзориг Л.Хаш-Эрдэнэ
2	Сумдын Сонгуулийн хорооны унааны зардлын гүйцэтгэлийг анхан шатны баримтад тулгуурлан хэсгийн хорооны ажилчдаас утсаар тодруулга авах байдлаар тулган баталгаажуулахад 1,684.2 мянган төгрөгийн шатахууныг зарцуулснаар тайлагнасан	1,684.2	Төлбөрийн акт тогтоох	Дарга, Нягтлан бодогч	Ц.Батзориг Л.Хаш-Эрдэнэ
3	Сонгууль зохион байгуулахтай холбогдуулан хуваарилагдсан санал авах байр бэлтгэх тохижуулах зардлаас төрийн далбаа худалдан авсан бэлтгэн нийлүүлэгчид олгосон 3,600.0 мянган төгрөг (И баримт) татварын нэгдсэн системд худалдан авалт хийсэн төлбөрийн баримт хэсэгт бүртгэгдээгүй	3,600.0	Албан шаардлага өгөх	Дарга, Нягтлан бодогч	Ц.Батзориг Л.Хаш-Эрдэнэ
4	Сонгууль зохион байгуулахтай холбогдуулан хуваарилагдсан албан томилолтын зардлын гүйцэтгэлийг тулган баталгаажуулахад 50.0 мянган төгрөгийг албан томилолтын хуудасгүй байхад олгосон	50.0	Төлбөрийн акт тогтоох	Дарга, Нягтлан бодогч	Ц.Батзориг Л.Хаш-Эрдэнэ
5	Сонгууль зохион байгуулахтай холбогдуулан хуваарилагдсан болзошгүй зардлаас 9,801.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан	9,801.0	Албан шаардлага өгөх	Дарга, Нягтлан бодогч	Ц.Батзориг Л.Хаш-Эрдэнэ



Байгууллагаас ирүүлсэн хариу


ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭ
ᠰᠣᠩᠭᠠᠭᠤᠯᠢ ᠬᠣᠷᠤᠭ

82093 Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Жинст баг
E-Mail: govialtai@songuuli.gov.mn
Утас: 7048-4560

2021. 07. 08 № 31

танай _____ -ны № _____ -г

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021
оны ээлжит сонгуулийн аймаг, сумдын
сонгуулийн хорооны зардлын тайланд
хийгдсэн аудитын тайлангийн дүгнэлттэй
танилцлаа.

Аудитаар өгөгдсөн зөвлөмж, албан
шаардлагыг хэрэгжүүлэн ажиллана.

ДАРГА  Ц.БАТЗОРИГ





Тэмдэглэл

АУДИТЫН II БАГ